

Увс аймгийн ИТХурал, Тэргүүлэгчдээс

2013 онд хийсэн ажлын тайлан

Нэг. Зохион байгуулсан ажил , үйл ажиллагааны үр дүн

Аймгийн ИТХ-ын 2013-2016 оны бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааны чиглэлүүдэд тусгагдсан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлж, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх болон НӨУБайгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлын хүрээнд 2013 оныг “Шууд ардчилал- иргэдийн оролцоог дэмжих жил” болгон аймгийн ИТХ, ажлын албаны 2013 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллав.

Аймгийн ЗДТГ, бүх сумдын ИТХ-ын дэргэд иргэний танхимыг байгуулан, тэнд ажиллах ажилтнуудад сонгон шалгаруулалт явуулан томилгоо хийж иргэдэд хууль, эрх зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, ИТХ-ын болон тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх асуудал, ялангуяа төсөв, ОНХС-ийн зарцуулалт, хөрөнгө оруулалт, зээл тусламж, хөтөлбөр төслүүдэд хамруулах асуудлыг олон нийтийн болон багийн ИНХ-аар хэлэлцүүлэг зохион байгуулж эрэмблэн шалгаруулж, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах, бүх шатны ИТХ-ын хороод, төлөөлөгчид тогтоосон хуваарийн дагуу иргэдтэй уулзалт ярилцлага хийж санал хүсэлтийг нь сонсох, бодлого зорилтоо сурталчлах, үйлчилгээний байгууллагууд ажлаа тайлагнаж, түүний хүртээмж чанар, ил тод шуурхай байдлыг хэрэглэгчид, иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг үндэслэн үнэлэх , түүнд тулгуурлан үйл ажиллагааг нь сайжруулах, иргэний танхим, утас, цахим хаяг зэрэг орон нутагт байгаа бүхий л арга хэрэгслээр иргэдийн санал гомдол, өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, хариу өгөх ажлууд хийгдэж хэвшиж байна.



Аймгийн иргэний танхимаар зохион байгуулсан 10 удаагийн хэлэлцүүлэгт 1337 хүн оролцож, 7 удаагийн санал асуулга явуулж, 9 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн телевизээр иргэдэд хууль эрх зүйн сурталчилгаа явууллаа.

Аймгийн Иргэний танхимаар хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн Улаангомыг хот болгон хөгжүүлэх, сумдын тохижилтыг сайжруулах, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, хариуцлагатай уул уурхай болон бичил уурхайг хөгжүүлэх, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, газрын хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, газар зохион байгуулалтын ажлыг сайжруулах, орон сууцжуулах, орон нутгийн өмчийн бүрдэлт, ашиглалт, хамгаалалтын менежментийг сайжруулах, ОНХ-ийн сангийн хөрөнгийн үр дүнд бий болсон бүтээн байгуулалтын ажилд Хурлаас хяналт тавих зэрэг асуудлаар тогтоол шийдвэр гаргалаа. Аймгийн иргэний танхимд шуурхай мэдээлэл хүлээн авах, дамжуулах цогц системтэй болгов.

Аймгийн ИТХ-ын анхдугаар болон 2-р хуралдааныг 2012 оны 11,12-р сард хуралдуулж төлөөлөгчдийн бүрэн эрхийг баталгаажуулж Хурлын дотоод зохион байгуулалтын асуудлыг

хуулийн хүрээнд бүрэн шийдвэрлэсний дээр Хурлын үйл ажиллагаанд мөрдөх журмуудыг /төлөөлөгчдийн ажиллах журам, тэргүүлэгчдийн ажиллах журам, Хороод, намын бүлэг ажиллах журам, Хурлын болон тэргүүлэгчдийн хуралдааны дэг, бэлтгэл хангах журам г.м/ хэлэлцэн батлаж, хурлын хороодыг зохион байгуулж, шинэ байгуулагдсан Хурал үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөл боллоо. Түүнчлэн ажлын шаардлагыг үндэслэн аймгийн ИТХ-ын 5-р хуралдаанаар аймгийн ИТХ-ын хуралдааны байнгын дэг, хороодын ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны журмуудыг 8 хавсралттайгаар шинэчлэн, төлөөлөгчдийн ёс зүйн дүрэм, хороодын ажиллах бүтцүүдийг шинэчлэн тогтоосон нь Хурлын дотоод үйл ажиллагааны хөгжил төлөвшилд чухал ач холбогдолтой боллоо.



Аймгийн ИТХ-аас аймгийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 5 бүлэг, 172 зорилгоор тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх 552 арга хэмжээг батлан, жил бүр хэрэгжилтэнд нь хяналт тавьж, үр дүнд нь үнэлэлт дүгнэлт өгч байхаар тогтоож, аймгийн 2012-2016 оны хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэв. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцаж эрчимжүүлэх, үр дүнг нь нэмэгдүүлэх, дутагдлыг нь засаж баяжуулах чиглэлээр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, хороод, төлөөлөгч нэг бүр өнгөрсөн хугацаанд байнга анхаарал тавьж бодлого үйл ажиллагаагаа чиглүүлж ирсэн нь Хурлаас гаргасан шийдвэр, санал дүгнэлтүүд, хяналт шалгалт, хэлэлцүүлэг, санал судалгааны дүн зэрэгт тусгалаа олсон байна.


Аймгийн ИТХ-ын 2013 оны ажлын төлөвлөгөөнд бүгд 115 ажил, арга хэмжээг зохион байгуулж хийхээр төлөвлөсний 69 бүрэн, 25 нь бүрэн бус, 15 нь хагас биелэлттэй, 3 ажлыг Улаангом сум руу шилжүүлсэн, 3 ажил биелэх боломжгүй буюу дундач нь 85%-ийн биелэлттэй, харин цаг үеийн шаардлагаар 15 ажил арга хэмжээг нэмж хийсний дээр тэргүүлэгчдийн хурлаар 20 асуудлыг нэмэлтээр хэлэлцсэн байна.

Аймгийн ИТХурал, ажлын алба хамтдаа 2013 онд 225,2 сая төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт төсвийн 52.9% нь ажлын албаны ажилчдын цалин урамшуулал, НДШ-д, 5.2% нь дотоод, гадаад томилолтонд, 5.7% нь тээвэр шатахууны зардалд, 2.6% нь бичиг хэрэгт, 2% нь шуудан холбоонд, 9.7% хуралдааны зардалд, 8.5% нь намын суудалд, 1.4% нь мэдээлэл сурталчилгааны ажилд, 2.1% нь нэг удаагийн зардалд, 3.1% нь

ГХУСАЗЗөвлөлийн, 1.6% нь цагаатгалын комиссын ажилд, 2.8% нь ном хэвлэл, эд хогшил худалдан авах, 3% нь төлбөр хураамж бусад зориулалтаар тус тус зарцуулагдаж байна.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн 27 нь буюу 65 хувь нь анх удаагаа сонгогдсон, аймгийн ИТХ-ын 2013 оны төсөвт төлөөлөгчийн үйл ажиллагааны зардал тусгагдаагүй зэрэг хүндрэл, шалтгаан байсан боловч төлөөлөгчдийн үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын 2013 оны төсвийн 14,6 хувь буюу нийтдээ 33 сая төгрөгийн зардал гаргаж, тэднийг богино хугацаанд сонгуульт үүргээ биелүүлэхэд нь сургаж дадлагажуулах, туршлага, ажлын арга барил бүтээн байгуулалттай танилцуулах, мэргэжил арга зүйн туслалцаа, шаардлагатай лавлагаа мэдээллээр хангах, үйл ажиллагааг нь журамлан зохион байгуулах, оролцоог нь дээшлүүлэх, гаргасан идэвхи санаачлагыг нь дэмжин хөгжүүлэх зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулснаар аймгийн ИТХ, түүний зохион байгуулалтын бүх нэгж хэсгүүдийн үйл ажиллагаа тогтворжин төлөвших хандлагатай боллоо.

Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоож, хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлэг явуулан батлаж мэргэжилтнүүдийн ажлын байрны чиг



үүргийн шинжилгээ хийж давхардлыг арилган ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн хуралд үйлчлэх чадавхийг сайжруулж ажиллалаа. Ажлын албыг удирдах, бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах гэсэн 3 түвшинтэй мэргэжилтнүүдийн баг болгож шинэчлэн зохион байгуулснаар хурлын төлөөлөгчид, тэргүүлэгчид, хороод, бүлэг, сум багийн хурал зэрэг

зохион байгуулалтын хэлбэр, бүтэц бүрт хүрч мэргэжлийн зөвлөлгөө, арга зүйн туслалцаа, техник зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх чадавхи, боломж нь дээшилж, НӨУБ-дын ажлын үр дүн, мэргэжлийн онцлог, арга хэлбэрийн хөгжилд ахиц өөрчлөлт гаргах бололцоо нэмэгдлээ.

Хурлын хороод 2013 онд тус бүр 8 хяналт, боловсруулалтын ажил хийж, Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх, хуралдааны бэлтгэл хангах асуудлаар 21 удаа хуралдаж, хяналт шалгалт явуулах, судалгаа хийж санал дүгнэлт гаргах, баримт бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах ажлыг зохион байгууллаа. Энэ ажилд Улаангом суманд амьдардаг аймгийн ИТХ-ын төлөөлөгчид зонхилон идэвхтэй оролцсон. Хороодын ажлын үр нөлөөг дээшлүүлэх, ажиллах орчин бүрдүүлэхэд ахиц өөрчлөлт гарч цаашдаа нийт төлөөлөгчдөө жигд татан оролцуулж байнгын үйл ажиллагааг явуулахад анхаарч байна.

Аймгийн ИТХ-аас Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан барилга, байгууламжийг ашиглалтад хүлээж авах улсын комиссын бүрэлдэхүүнд ашиглагч, өмчлөгч, хууль тогтоомжоор үүрэгжүүлсэн төлөөллийг баг болгон оролцуулах менежментийг бий болгох, төсөл, зээл, тусламж, хандиваар орон нутагт бий болсон хөрөнгийг тухай бүрийд нь бүртгэлд тусгаж хяналт тавих, өмчийг зориулалтын дагуу үр ашигтай ашиглуулах, эзэмшилт, ашиглалтгүй байгаа өмчийг хуулийн этгээдэд эзэмшүүлэх өмчийг зүй

бусаар ашиглах, завших, элдэв хэлбэрээр үрэгдүүлэх явдлыг таслан зогсоох, өмчтэй холбоотой аймгийн мэдээллийн сан бүрдүүлэх талаар Засаг даргад үүрэг чиглэл өглөө.

Орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулах талаар сумдыг мэдээлэл, зөвлөмж, удирдлагаар хангах арга хэмжээ авч эдгээр ажлыг цаашид улам боловсронгуй болгон хэвшүүлэхэд анхаарал тавьж байна. 2013 онд ашиглалт, эдэлгээний норм дууссан 60 байгууллагын 1183420,9 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг шийдвэрлэхээр 9 тогтоол гаргасны хэрэгжилт нь 97,3 хувьтай байна. Шийдвэрүүдийг хэрэгжүүлснээр 2013 онд нээлттэй дуудлага худалдаанаас 85684,8 мянган төгрөг, түрээснээс 14213,8 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод оруулж, өмнөх оны 1980,0 мянган төгрөгийн авлагыг барагдуулжээ.

2012 оны эцэст явуулсан тооллогын дүнгээр орон нутгийн өмчит 179 байгууллагад 131 тэрбум 713 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгө тоологдсоноос: Барилга байгууламж 101 тэрбум 213,3 сая, машин тоног төхөөрөмж 11 тэрбум 930,6 сая, тээврийн хэрэгсэл 4 тэрбум 432,9 сая, тавилга эд хогшил 4 тэрбум 401,2 сая, түүх соёлын дурсгалт зүйл 104,2 сая, Ном 596,3 сая, дуусаагүй барилга 5 тэрбум 814,9 сая, биет бус хөрөнгө 92,6 сая, бусад 3 тэрбум 127,7 төгрөгийн үнэтэй үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.

Аймаг, сумдын ИТХ-ын ажлаа дүгнэж ОНЦЛОХ мэдээний дугаарыг сар бүр гаргаж аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын ИТХ, холбогдох байгууллагуудад хүргүүлдэг боллоо.

Аймгийн Иргэний танхимаар иргэдийн санал бодлыг сонсох хүлээн авах 1 сарын ажлын хүрээнд 12 төлөөлөгч хуваарийн дагуу ажиллаж иргэдийг хүлээн авч тэдний саналыг сонсох үед гаргасан 42 санал хүсэлтийг шийдвэрлүүлэхээр холбогдох 12 байгууллагад уламжлан танилцуулж, хариу өгүүлэх ажил зохион байгууллаа.



Аймгийн ИТХ-ын 4 дүгээр хуралдааны үеэр төлөөлөгчдөөс гаргасан 33 асуудал хөндсөн санал шүүмжлэлийг

холбогдох 11 байгууллагад албан тоотой хүргүүлэн хариу авч төлөөлөгч бүрт, мөн холбогдох хурлын хороодод тухай бүр нь цахимаар хүргүүлэх арга хэмжээ авч, цаасаар хэвлэсэн нэгтгэлийг нь хороодын ажлын танхимд тавьж танилцууллаа.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөөс ОНХСангийн хөрөнгөөр сумдад хийгдэх ажлаар иргэдийн санал судлахад 452 санал шүүмжлэл гарсныг 23 албан байгууллага, холбогдох албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр хүргүүлэхэд түүнээс 21 байгууллага хариу ирүүлсний дотор 71 саналын мөрөөр тодорхой ажил зохион байгуулагдаж, 9 асуудлыг ЗГХЭГ, холбогдох яаманд уламжилж, 167 саналыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, бусад орон нутгийн бодлогод тусгаж, 104 ажлыг сум, холбогдох байгууллагуудад шийдвэрлүүлэхээр шилжүүллээ.

Орон нутгийн телевизүүдээр аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд үйл ажиллагаагаа сурталчлах цаг тогтоож өгснөөр Улаангом суманд амьдардаг 11 төлөөлөгчид тойрогтоо болон аймгийн хэмжээнд хийж хэрэгжүүлсэн ажлаа орон нутгийн МВС,САМА телевизүүдээр мэдээлэн

сурталчилж бусад төлөөлөгчид сонины нүүр гаргах зэрэг хэвлэмэл байдлаар ажлаа тайлагнав.

Аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын 2013 оны эхний 3 улирлын дүнгийн тухай статистик мэдээллийг үндэслэн нийтлэг 9 асуудлаар Аймгийн Засаг даргад асуулга тавьж, хариуг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн Засаг даргад 7 үүрэг, чиглэл өгсөн тогтоол гаргалаа. Аймгийн ИТХ-аас баталсан удирдамжийн дагуу аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, ажлын алба, ЗДТГ-тай хамтарсан ажлын хэсгийг 2 удаа томилон сумдын ИТХ, иргэний танхим болон сумын ажилтай танилцаж, зөвлөмж, чиглэл өгч, цаг үеийн ажлаар иргэдтэй уулзаж санал хүсэлтийг сонсох ажлыг зохион байгууллаа. Эхний ажлын дүнг үндэслэн сум, багийн ИНХ, иргэний танхимын ажлыг боловсронгуй болгож сайжруулах тухай аргачилсан зөвлөмж гарган аймгийн ЗДТГ-т хүргэв. Хоёр дахь ажлын хэсэг сумдын Хурал, ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, иргэний танхимын ажилтнуудын ажилтай танилцаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн шилдэг ИТХ-ын дарга 3, нарийн бичгийн дарга 3, иргэний танхимын ажилтан 3, Хурлын ажлын албаны шилдэг ажилтан нэг, аймгийн ИТХ-ын шилдэг төлөөлөгч гурван хүнийг тус бүр шалгаруулж аймгийн ИТХ-ын хүндэт медальон, дурсгалын зүйлээр шагнаж алдаршуулав.

Аймгийн сургалт семинарын графикийн дагуу болон сангийн яам бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт, ажил төрлийн семинарт сумдын ИТХ-ын дарга нар 4, сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар 2, багийн Засаг дарга, багийн ИНХ-ын дарга нарт 1 удаа, иргэний танхимын ажилтнууд 2 удаа тус бүр хамрагдаж Наранбулаг сумын ИТХ-ын төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга, тэргүүлэгчдэд, зүүн бүсийн 7 сумын Хурлын дарга, нарийн бичгийн дарга, Өндөрхангай сумын ИТХ-ын зарим төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга зэрэг бүгд 36 хүнийг хамарсан ажил төрлийн сургалт семинарыг тус тус зохион байгуулав.

МНУХ, Мерси Кор ОУБ-ын хамтарсан сумын хөгжлийн хөтөлбөр боловсруулах төсөлд 2013 онд шинээр 6 сумыг нэмж хамруулсан ба аймгийн ИТХ-ын төлөөлөгч Т.Эрдэнэбатын удирдлагаар хөгжлийн хөтөлбөр боловсруулалтын ажил хийгдэж байна. Мөн Мерси Кор ОУБ-ын Увс аймаг дахь салбартай хамтран багийн ИНХ-ын дарга, Засаг дарга, сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд 4 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 170 орчим хүн хамрагдлаа.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын сангийн санхүүжилтээр хурлын төлөөлөгчдийн болон хурлын ажлын алба ажил үүргээ хэвийн явуулах нөхцлийг хангасан худалдан авалт хийснээс хурлын ажлын албаны тоног төхөөрөмж сайжирч, ажлын байранд их засвар хийгдэж, эд хогшил, техник хангамж, автомашины парк шинэчлэгдлээ. Түүхэн танилцуулгын булан, Хурлын хороод болон төлөөлөгчид ажиллах интернетийн сүлжээ бүхий Хууль эрх зүйн болон бусад шаардлагатай мэдээлэл лавлагаа авах, мэдээллээ компьютер дээр боловсруулах бололцоотой танхимыг байгууллаа.


Хорооны ажлын танхим нь Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн ИТХ-ын Үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, хяналт шалгалтын байгууллагын

тайлан зэрэг нийтлэг ач холбогдол бүхий бичиг баримтуудыг байнга ашиглах, танилцах, төлөөлөгчид сууж ажиллах бололцоотой боллоо.

Аймгийн ИТХ-ын хуралдааны танхимд Smart Voter System /SVS/ систем нь ухаалаг утас, тавлет зэрэг ухаалаг төхөөрөмжид суурилсан хурлын санал хураалтын систем суурилууллаа. SVS систем нь санал өгөх Smart Voter мобайл программ, PC Voter нөүтбүүк буюу персональ компьютерийн программ болон Smart Vote удирдлагын программ гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Ажиллагааны хувьд цаг бүртгэл, санал хураалт, санал бүртгэл, асуулт бүртгэл гэсэн 4 горимтой. Хурлын бүх горимын бүртгэлийн мэдээлэл удирдлагын программын мэдээллийн санд хадгалагдах бөгөөд хүссэн үедээ дурын сонголтоор тайлан, мэдээ авах боломжтой цогц системийг ашиглах боломжтой боллоо.

Мэдээллийн шинэ тогтолцоо бүрдүүлэх талаар Аймгийн ИТХ нь албан ёсны вэб сайт /www.khural.uv.gov.mn/-тай, мөн Facebook сайтанд групп /www.facebook.com/groups/uvs.ith/ харилцан мэдээлэл солилцох техник хангамжийг бүрдүүллээ.

Аймгийн ИТХ-ын 41 төлөөлөгчдийг цахим техник хангамжтай болгож мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх технологийн нөхцлийг бүрдүүлснээр төлөөлөгчид и-мэйл хаягтай болж зар мэдээ, хуралдааны болон тэргүүлэгчдийн хурлын танилцах материалыг цахим хэлбэрээр явуулдаг боллоо. 2013 онд нийт төлөөлөгчдөд 54, хариутай 17 албан бичиг цахимаар явуулсан. Аймгийн ИТХ-ын ажилд төрийн байгууллагуудын удирдлагын цогц систем Авле программыг амжилттай нэвтрүүллээ.



Хоёр. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаан

2013 онд аймгийн ИТХ-ын хуралдааныг 4 удаа 91,1 хувийн дундаж ирцтэй хуралдуулж, 18 асуудал хэлэлцэж 181 заалт бүхий 45 тогтоол шийдвэр гаргаж давхардсан тоогоор төлөөлөгчид 164 санал шүүмжлэл гаргаснаас 88 санал хурлын шийдвэрт туссан байна. Хуралдааны бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг гаргаж, урсдаг самбар, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, хуралдааны явцыг орон нутгийн 2 телевизээр шууд болон хэсэгчлэн дамжуулан нэвтрүүлж байна.

Аймгийн ИТХ-ын **3-р хуралдаан** 2013 оны 1-р сард хуралдаж аймгийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай аймгийн Ерөнхий прокурорын мэдээлэл, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн

үйл ажиллагааны төлөвлөгөөг дэмжих, аймгийн 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хэлэлцэв.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус **4-р хуралдаан** 5-р сард хуралдаж аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон Түмэнжаргалын Болдын бүрэн эрхийг зөвшөөрөх, аймгийн 2013 оны төсөвт тодотгол хийх асуудлыг авч хэлэлцээд төлөөлөгч Т.Болдын бүрэн эрхийг зөвшөөрч тогтоол гаргаж, төлөөлөгчийн үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Мөн аймгийн ИТХ-ын төсвийн тодотголыг хэлэлцэн ОНХС-аас улсын төсвийн байгууллагуудын хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан 433.2 сая төгрөгийг төсвийн хуулинд нийцүүлэн дахин хуваарилав.

Урьд оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 577.2 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын ажилд зарцуулах тогтоол гаргалаа.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус **5-р хуралдаан** 12-р сарын 2-нд хуралдаж 7 асуудал хэлэлцэж 6 тогтоол гаргаж, төлөөлөгч Д.Ганболдыг ОХУ-ын Тува улсад консулаар ажиллах болсон тул төлөөлөгчөөс чөлөөлж, жагсаалтаас Ж.Оюунцэцэг төлөөлөгчөөр сонгогдож бүрэн эрхийг нь зөвшөөрч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээс Ж.Александр, Д.Ганболд нарыг чөлөөлж М.Ганбаатар, Б.Гомбосүрэн нар нөхөн сонгогдов.

Аймгийн 2013 оны төсөвт тодотгол хийж, аймгийн 2012 оны төсвийн гүйцэтгэлийг батлав. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг баталж, цахим санал хураалт явуулах болсонтой холбогдуулан Хурлын үйл ажиллагааны журмууд, ИТХ-ын хороог 5 болгож, нэрийг нь өөрчлөн, 18-24 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан.

Аймгийн ИТХ-ын **6-р хуралдаан** 12-р сарын 3-5-ны өдрүүдэд хуралдаж 7 асуудал хэлэлцэж зохих шийдвэр гаргалаа. Аймгийн ИТХ-ын 3 төлөөлөгчийг чөлөөлж нөхөн сонгууль хийхээр тогтов. Аймгийн ИТХ, аудитын газрын 2013 оны ажлын тайланг хэлэлцээд “Хангалттай ажилласан” гэж дүгнэв.

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2013 оны зорилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг дүгнэж, аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх 91 зорилт дэвшүүлж, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бүтээн байгуулалтын ажлын 51 төсөл, арга хэмжээний жагсаалт, 2014 оны төсөв, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батласан.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн хэсэг Бөхмөрөн суманд ажиллаж ОНХС, бусад эх үүсвэрээр хийгдэж буй бүтээн байгуулалт, сумын ажилтай танилцаж орон нутгийн хөгжлийг дэмжихэд анхаарах уул уурхайн болон бусад орон нутгийн тулгамдсан асуудалд аймгийн хурлын төлөөлөгчдийн шийдвэр гаргах түвшний оролцоог бий болгоход дэмжлэг үзүүллээ.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгч 10 гаруй хүнийг төвлөрсөн болон гадаад арга хэмжээнд оролцуулах, дэмжлэг үзүүлэх, хурлын төлөөлөгч болон аймаг сумын ИТХурал, ЗДТГ-ын ажилтан 12 хүнийг төвлөрсөн сургалт семинарт хамруулж, төсөл хөтөлбөрөөр сургагч багш бэлтгэх, мэргэшлийг нь дээшлүүлэх арга хэмжээ авч ажилласан ба “Мерси Кор” олон улсын байгууллагатай хамтран сумын иргэний танхимын ажилтны арга зүйн сургалт, туршлага

солилцох уулзалтыг явуулснаар иргэний танхимын ажилтнууд өөрсдийн ажлаа танилцуулж сар бүр харилцан туршлага солилцдог боллоо.

Сумдын ИТХурлын хуралдаан 62 удаа, Тэргүүлэгчдийн хурал 309 удаа, багийн ИНХурал 310 удаа хуралдаж орон нутгийн цаг үеийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 1015 асуудал хэлэлцэн 1953 заалт бүхий 1099 тогтоол гаргажээ.

Сумын ИТХ-аас санаачлан зохион байгуулсан онцлог ажлаас дурьдвал:

Давст сум: 2013 онд *“Архигүй, Авилгагүй, Аргалахгүй”* гэсэн зорилт дэвшүүлж амжилттай хэрэгжүүлсэн. Гурван “ А”-г дэмжих жагсаалд сумын 400 гаруй иргэн, хүүхэд залуучууд нэгджээ.

Сумын ИТХ болон тэргүүлэгчдийн хуралдааныг соёлын төвд нээлттэй хийж иргэдийн саналыг сонсох, ажлаа дүгнүүлэх зэргээр шууд ардчиллыг хөгжүүлэх санаачлага гаргасан. Багийн ИНХ-ын даргын ажлын байрны тодорхойлолт гарган мөрдүүлж, багийн ИНХ-ыг улирал бүр хуралдуулж хууль, тогтоомж сурталчилах мэргэжлийн зөвлөх багийн үйлчилгээг хөдөөгийн иргэдэд тогтмол хүргэж байна.

Сар бүр сумын ИТХ, иргэний танхимаас хийж байгаа ажлын тухай мэдээ мэдээллийг хэвлэмэл хуудсаар айл өрх, албан байгууллагуудад хүргэж үйл ажиллагаагаа сурталчилж байна.

Зүүнговь сум: Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг багийн ИНХ-аар хэлэлцүүлж төсөл бичсэн 13 аж ахуйн нэгж, иргэн төслөө танилцуулж хамгаалах ажлыг хийж төслийг санхүүжүүлэх эсэх асуудлыг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэв.

Багийн ИНХ-д иргэдийн оролцоог хангах зарыг гар утас, FM радиогоор хүртээмжтэй хүргэдэг, байгууллага бүрт мэдээлэл дамжуулах ажилтан ажиллуулж багийн ИНХ-ыг хангалттай төлөөлөлтэйгээр явуулж хэвшүүлэн Хурлаас гарах шийдвэрийг илүү бодитой болгоход дэмжлэг үзүүлсэн.

Бөхмөрөн сум: Сумын төвийг хөгжүүлэх зураглал, төлөвлөгөө хийж 2012-2013 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гудамж, талбайн тохижилтонд 45 ширхэг гэрэлтүүлэг, 20 ширхэг хогны сав бүхий 2 км сайжруулсан, 800 м явган хүний зам тавьж явган хүний зам дагуу 1600 м² талбайг зүлэгжүүлэв.

Багийн төвд түшиглэсэн “Мини” иргэний танхим ажиллуулж хэлэлцүүлэг, санал авах болон хууль, эрх зүйн зөвлөн туслах үйлчилгээг тогтмол явуулж, мэдээ мэдээллийг хүн амын насны онцлогт тохируулан бэлтгэж хүргэдэг

Ховд сум: Сар бүр *“Миний амжилт”* хэлэлцүүлгийг иргэд, байгууллагуудыг оролцуулан зохион байгуулж иргэдэд ажлаа тайлагнаж, 14 хоног тутамд *“Мэдээллийн цаг”* танин мэдэхүйн сургалт сурталчилгаа, шинэчлэлийн бодлогыг сурталчлах ажлыг ИТХ-аас зохион байгуулж хэвшсэн. Сумын ИТХ-ын болон Хороод, багийн ИНХ-ын ажиллах журам, Иргэний танхимын журмыг тус тус шинэчлэн батлаж, хурлын дотоод ажлын стандартыг сумын хэмжээнд гаргаж түүнийхээ дагуу бичиг баримтын бүрдэлтийг хангаж, иргэдээс ажлын төлөвлөгөөнд

тусгах санал, төрийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн болон авилгын талаар судалгааг авч ажлаа төлөвлөдөг болжээ.

Өндөрхангай сум: Багийн ИНХ-ын дарга нарыг хурал удирдах, бичиг баримт боловсруулах тэмдэглэлээ бүрэн зөв хөтлөх, мэдээ тайлан гаргах, хамт олныг манлайлан зохион байгуулах, иргэдийн оролцоонд тулгуурлан ажлаа төлөвлөх сургалт зохион байгуулав. Сумын ИТХ-ын ажлын тайланг хэвлэмэл хуудсаар улирал бүр иргэдэд хүргэж, хурлын хороодыг аж ахуйн нэгж, байгууллага бүр дээр ажиллуулж үр дүнг хорооны хурлаар хэлэлцүүлдэг.

Сумын эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаанд эдийн засаг, төсвийн асуудал эрхэлсэн хороо, Цэцэрлэг багийн ИНХ-ын дарга, “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, дотуур байрны хоолны чанар, хүртээмжид ХАА, ЖДҮ –ийн асуудал эрхэлсэн хороо, байгаль орчны асуудал эрхэлсэн хороо, Цалуу багийн ИНХ-ын дарга, сургуулийн сурагчдын стандарт хангалт, багш нарын боловсролын баримт бичиг, хичээлийн бэлтгэлд сумын төвийн ИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ, Хүнсний дэлгүүр, агуулах, гал тогоо бүхий газруудад ЗДТГ-ын мэргэжилтнүүд, олон нийтийн байцаагч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, Хэрэгцээний модны лимит, ашиглалтанд Байгаль орчны асуудал эрхэлсэн хороо, ЖДҮ-ийн зээл, Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтанд хяналт хийж ашиглалтгүй болсон хөрөнгийг актлах, устгах, илүүдэл хөрөнгийг дуудлага худалдаанд оруулж, хандив тусламжийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгүүлэх зэрэгт бусад хороод хяналт хийж, санал дүгнэлт гарган Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсэн.

Наранбулаг сум: Сумын хурлын төлөөлөгчдийн дагаж мөрдөх журам боловсруулан хэрэгжүүлж сумын ИТХ-ын төлөөлөгчдийн “НЭГ ӨДӨР” арга хэмжээг тогтмолжуулж төлөөлөгчид иргэдээр ажлаа үнэлүүлдэг болсон.

Тариалан сум: Сумын ИТХ-ын шийдвэрт бүртгэл, хяналтын карт хөтлөн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдэд өгч хариуг хугацаанд нь мэдээлдэг, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал, Засаг даргын зөвлөлийн хуралд Хурлын дарга, Засаг дарга нарыг харилцан урилгаар оролцуулдаг, ЗДТГ-тай хамтран төрийн үйлчилгээний байгууллагуудад дотоодын хяналт шалгалт зохион байгуулж дүнг ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэж үүрэг даалгавар өгч, ЗДТГ-аас зардал гаргаж төлөөлөгчдийг сонгогдсон баг тойрог бүрт нь хүргэж ажиллуулдаг.

Цагаанхайрхан сум: Сумын ИТХ-аас 845 км замыг туулан, хөдөөгийн гурван багийн 133 өрх айлаар орж төр засгийн бодлого шийдвэрийг сурталчилж, амьдрал ахуйтай нь танилцан иргэдийнхээ санал бодлыг сонсож, төвийн 11 хороололд цуглаан хийж иргэдтэй уулзан гарсан саналуудыг нэгтгэн эрэмбэлж ажлаа төлөвлөн ажиллаж эхэлсэн. Иргэний танхим нь сумын иргэдэд хууль, эрх зүйн зөвлөн туслах үйлчилгээ, сурталчилгааг олон нийтийн арга хэмжээнүүдтэй хамтруулан тогтмол зохион байгуулдаг. Иргэдээс судалгаа авч баг, сумын Хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулахад дэмжлэг үзүүлсэн.

Зүүнхангай сумын Иргэний танхим: Аймгийн Хөдөлмөрийн хэлтэсээс хэрэгжүүлж буй “Эзэнтэй монгол” төслийн хүрээнд Сумын тохижилт, Ногоон байгууламж гэсэн 2 төсөл бичиж

10 нь буюу 11,1% нь бусад асуудалтай холбоотой байгаа нь аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой байдлыг хангаж ажилласныг харуулах болно.

Аймгийн ИТХ, тэргүүлэгчдээс аймаг, сумдын хөгжлийн дунд, урт хугацааны бодлогод хамаарах Хархираа-Түргэний дэд, Хяргас нуур- Завхан голын сав газрын усны нөөцийн менежментийн нэгдсэн төлөвлөгөө, давсны хэрэглээг багасгах, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөрүүд, статистикийн салбарын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үл хөдлөх эд хөрөнгийн татварын хувь хэмжээг тогтоох, тендерийн бичиг баримтын борлуулалтын орлогыг зарцуулах, нийгмийн эрүүл мэндийн зөвлөлийн ажиллах, үндэсний аюулгүй байдлын асуудлаарх мэдээллийн журмууд, нийгмийн халамжийн үйл ажиллагааг сайжруулах, хоршоо хөгжүүлэх, багийн талаар авах арга хэмжээ, дулаан хангамж, өвөлжилтийн бэлтгэл, асуулгад өгсөн хариуны тухай гэх мэт тодорхой салбар, чиглэлийн хөгжлийн бодлогын баримт бичиг, шийдвэрүүдийг гаргалаа.

Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх аливаа асуудлыг урьдчилан иргэний танхимаар холбогдох талуудыг оролцуулсан хэлэлцүүлэгт оруулж, гарсан саналыг хурлын хороон дээр нэгтгэн эрэмбэлсний дараа тэргүүлэгчдийн болон хурлын хуралдаанд оруулдаг хэвшил тогтож хурлын байнгын идэвхтэй үйл ажиллагаа төлөвшиж байна. Тэргүүлэгчдэд улиралд 90000 төгрөгийн урамшуулал олгож байна.

2013 онд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаас иргэдийг төрийн одон медальд тодорхойлж шагнуулах ажлыг зохион байгууллаа.

Төрийн шагнал	2013 онд тодорхойлон ЕТГ-т уламжилсан, тоо	2013 онд шагнагдсан, тоо	Өмнөх онуудад тодорхойлогдон шагнагдсан, тоо	2013 онд шагнагдсан, нийт тоо
Ардын цол	2	0	0	0
Гавьяат	18	1	0	1
ХГУТО	18	13	2	15
АГО	105	56	23	79
ХХМ	87	35	17	52
Цэргийн гавьяа	0	0	1	1
Алдарт эх I	0	0	67	67
Алдарт эх II	0	0	336	336
Шудрага журам	14	0	0	0
Нийт, одон	244	105 43%	43	148 61%
Нийт, <i>Алдарт эх</i>			403	403

Мөн аймгийн ИТХ-аас баяр ёслол тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан НӨУБ, нутгийн захиргааны байгууллагын ажилтнууд, бүх салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид, хувиараа хөдөлмөр, бизнес эрхлэгчдийн төлөөлөл болох 23 хүнийг “хүндэт өргөмжлөл”-өөр, 20 хүнийг баярын бичгээр, 6 хүнийг талархал мөнгөн шагналын хамт шагнаж урамшууллаа.

Дөрөв. Хяналт шалгалтын ажил

Аймаг, сумдын засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр, ажлын тайланг нь хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх явдал хэвшиж байгаагийн дээр хурлын хороод, түр хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулах, асуулга тавих, хөндлөнгийн болон дотоод хяналтын байгууллагуудад захиалга өгөх зэрэг арга хэрэгслээр хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал: Хурлын даргын захирамж, тэргүүлэгчдийн тогтоолоор түр хороо, ажлын хэсэг байгуулан тодорхой асуудлаар хяналт шалгалт, судалгаа мэдээлэл цуглуулах ажил хийж дүнг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлэх зорилгоор Дэчинравжаалин хийдийн үйл ажиллагаа, Дулааны станц-Чандмань-Увс компаниудын хоорондын өр авлага, суманд байгууллагуудын ажилтай танилцах, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, цаг үеийн тулгамдсан асуудлаар санал судлах зэрэг удирдамжтайгаар ажиллав.

Аймгийн ИТХ-ын хуралдаан дээр гарсан санал шүүмжлэл, иргэд байгууллагаас ирүүлсэн хүсэлт мэдээлэл, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрүүдтэй холбоотойгоор ИТХ-ын 2013 оны ажлын төлөвлөгөөнд дотоод хяналтын тогтолцоогоор буюу ажлын албаны хүрээнд 7 сэдвээр, аудитын газрын төлөвлөгөөнд тусгуулж төсвийн 6 байгууллага, орон нутгийн өмчийн 2 компанид санхүүгийн баримт, үр ашгийн байдалд гүйцэтгэлийн болон нийцлийн, гал тогоо бүхий төсвийн бүх байгууллагад хэрэгжүүлж байгаа үдийн цай хөтөлбөрийн санхүүгийн баримт, төсвийн байгууллагуудын бензин шатахууны зарцуулалтанд гүйцэтгэлийн аудит хийлгэх зэрэг нийдээ 16 багц асуудлаар үзлэг шалгалт, хяналт хийлгэхээр төлөвлөж аймгийн ИТХ-ын холбогдох хороод, тэргүүлэгчид, төлөөлөгчид болон ажлын албаны мэргэжилтнүүд, мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор зохион байгууллаа.

Зохион байгуулалт, хяналт шалгалтын дээрх ажлууд нь аливаа ажил, түүний дотор төрийн үйлчилгээнд байгаа дутагдал доголдолыг арилгаж, иргэдийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэн гомдол-бухимдал, доголдол-дутагдлыг засаж арилгахад, улмаар аймгийн хөгжил дэвшилд тодорхой хувь нэмрээ оруулж байна.

Нутаг дэвсгэртэй сахилга дэг журмыг бэхжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор Аймгийн ГХУСАСЗ-ийн шугамаар аймгийн хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн хийлгэж хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, тулгарч буй 10 асуудлыг тусгасан зөвлөмж гаргаж, аймгийн ГХУСАСЗ-эвлэлийн бүрэлдэхүүн ажиллах журмыг шинэчлэв. Салбар зөвлөлийн ажлыг хүний эрхийг хангах, аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих чиглэлд түлхүү анхаарч гэмт хэргийн гаралт,

шалтгаан нөхцөлийг судлах, холбогдох арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг татан оролцуулах, сум, багуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хурал зөвлөгөөнийг хамтран зохион байгуулах хүрээнд 29 ажил хийхээр төлөвлөснөөс удирдлага зохион байгуулалтын хүрээнд 11 ажил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны чиглэлээр 5 ажил, архидан согтуурах, тамхи, мансууралтай тэмцэх чиглэлээр 4, мал хулгайлах болон тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 4 ажлыг тус тус хийж гүйцэтгэлээ. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд архидан согтуурах танхайрах явдал буурч, тамхигүй цэвэр орчныг бүрдүүлж чадсан. Иргэд олон нийт гэмт хэрэг үйлдэх, түүний хор уршиг, хүлээх хариуцлагын талаар зохих мэдлэгтэй болж гэмт хэрэг гарсан даруй холбогдох газарт түргэн шуурхай мэдээллэхэд ахиц дэвшил гарсан.

Аймгийн ИТХ-ын ажлын албанаас авилгатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах талаар 2013 онд хийх ажлын төлөвлөгөө гарган, шударга ёс, ил тод байдлыг бэхжүүлэх "Ил тод байдлын самбар" ажиллуулж, НӨУБ-ын 548 албан тушаалтны Хөрөнгө орлогын мэдүүлгийг гарган Авлигатай тэмцэх газарт цахимаар хүргүүлээ.

Тав. Бусад ажил

Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж, энэ асуудлаар аймгийн ИТХ-аас шинэчилсэн журам батлан гаргаж, түүний хэрэгжилтэнд үзлэг явуулж, үйл ажиллагаа явуулах эрхийг шинэчлэн тогтоолоо.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн аймгийн сонгуулийн хорооны талаар санал өгч түүний бэлтгэл хангаж зохион байгуулах хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн биелүүлж аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, 3 мэргэжилтэн сонгуулийн хорооны болон техникийн багийн бүрэлдэхүүнд ажиллуулж, ажлын алба сонгуулийн ажилд бүх талын дэмжлэг үзүүлснээр сонгуулийг хуулийн хүрээнд ямар нэгэн зөрчил маргаангүйгээр зохион байгууллаа.

Аймгийн ИТХ-д "Залуучуудыг дэмжих лобби" бүлэг 21 гишүүнтэйгээр байгуулагдан залуучуудын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, тэдний дуу хоолойг төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлогод тусгуулах зорилготойгоор бүлгийн тэргүүнээр төлөөлөгч Т.Эрдэнэбат сонгогдон ажиллаж байна.

Ө.Бадрахын нэрэмжит цэцэрлэгт босгох улстөрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалын хөшөөний загвар зураг, эскиз хийлгэх, зураг төсөв зохиолгох, хэлмэгдэгсдийн дурсгал, цагаатгалын асуудлаар хийх эрдэм шинжилгээний бага хурлын болон хэвлүүлэх ном товхимолуудын агуулгын төлөвлөгөө, орох материалын эх бэлтгэх зэрэг ажлууд хийгдлээ. Шинэ Үндсэн хууль батлагдсаны ойд зориулсан шатрын аймгийн аврага шалгаруулах тэмцээнийг аймгийн ИТХ-аас зохион байгуулалтаар хангах зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.

2013 онд аймгийн ИТХ-д гаднаас 252 албан бичиг тоот ирснээс 220-ыг судлан шийдвэрлэж, тоотоор хариу өгч, одоогоор 30 нь судлагдаж байгаа, бусад хэлтэст 3-ыг

шилжүүлсэн, аймгийн ИТХ-ын нэр дээр иргэдээс бичгээр 12 өргөдөл гаргасныг судлан шийдвэрлэж хариу өгсөн.

Монголын НУХолбооны аймгийн салбараас холбооны гишүүн, дэмжигч байгууллагын дунд явуулах зохион байгуулалт, санхүү аж ахуй, мэдээлэл сурталчилгааны олон талт ажилд байнга анхаарч, идэвхтэй оролцож ирсэн ба “Нутгийн удирдлага” сэтгүүлийн захиалгыг нэмэгдүүлэх, түүнд өөрсдийн ажлын туршлага, танилцуулгаа хэвлүүлэх, багийн ИНХ-ын дарга, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн ширээний ном - харилцан туршлага солилцох, гарын авлага болгож ашиглахад анхааран ажилласны дүнд МНУХ-оос зарласан “Нутгийн удирдлага” сэтгүүл захиалах болзолт уралдаанд манай аймгийн ИТХ тэргүүн байр эзэлж, 6 сум тэргүүний сумаар шалгарч МНУХ-ны “Соёмбо” медалиар 9, “Нутгийн удирдлагын тэргүүний ажилтан” цолоор 5, “Хүндэт Өргөмжлөл” – өөр 4 хүн шагнагдлаа.

Аймгийн ИТХ-ын 2 төлөөлөгч төрийн албанд шилжсэн учраас чөлөөлөгдөж, 2 төлөөлөгч шүүхийн тогтоол гарсны улмаас огцорсон. Нэг төлөөлөгч намын жагсаалтаас нөхөн сонгогдсон. Аймгийн ИТХ-ын Түргэн, Өндөрхангай, Улаангом сумын 4-р багт нөхөн сонгууль 2014 оны 4-р сард явуулахаар төлөвлөж байна.

Өмнөговь сумын ИТХ-ын дарга Ш.Лхагвасүрэн, Малчин сумын Засаг дарга Б.Батсүх нар ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж ажлаасаа өөрчлөгдсөн.

Сумын ИТХ-ын 10 төлөөлөгч төрийн албанд шилжиж, 10 төлөөлөгч шинээр нөхөн сонгогдсон. Үүнээс нэг тойрогт нөхөн сонгууль явагдаж, 9 төлөөлөгч намын жагсаалтаас нөхөн сонгогдсон. Аймаг, сумын ИТХ тараагүй. Аймаг, сумын ИТХ-ын шийдвэрт Засаг дарга хориг тавиагүй.

Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт зохион байгуулах, төрийн одон медалиар шагнуулахаар тодорхойлогдсон хүмүүсийн шагнагдахгүй байгаа шалтгааныг эргэж мэдээлэх, УИХ-ын тамгын газар, ЗГХЭГ-ын шугамаар зохион байгуулагдах хурал зөвлөгөөн бусад арга хэмжээ болон Удирдлагын академи дээр явагдах захиалгат, хуваарьт сургалтанд Хурлын ажилтнуудыг хамруулах, НӨУБ-ын ажилтан, сонгуультны бүсчилсэн, төвлөрсөн семинар, уулзалт, гадаад дотоодын, соёл спортын, бусад арга хэмжээнд ИТХ-ын төлөөллийг оролцуулах, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардал, багийн ИНХ, иргэний танхимын үйл ажиллагааны зардлыг хурлын төсөвт тооцож тусгах, орон нутгийн төсвөөс хэмнэгдсэн болон орлогын давсан хөрөнгийг хурлын үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор зарцуулах, сумын Засаг даргыг нийтээр сонгодог болох, сум, багийн ИНХ-ын дарга нарт нас, боловсролын шалгуур тавих, цалин урамшууллыг нэмэгдүүлэх, аймаг, сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын эрх, үүргийг хуулинд тодорхой болгох, ИТХ-ын даргын цалин, урамшуулал, бусад төрийн албаны статус, баталгааг албан ёсны баримт бичигт тусгах зэрэг асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилж, зохих хууль, тогтоол шийдвэрүүдийг гаргуулах арга хэмжээ авахыг санал болгож байна.

Аймгийн ИТХ-аас 2014 онд дараах асуудлуудад анхаарч ажиллахыг зорилт болгож байна. Үүнд:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх нэн шаардлагатай дунд хугацааны бодлого,

- хөтөлбөрүүдийг ЗДТГ-тай хамтран гаргаж боловсруулж батлахад анхаарч ажиллах
- Бүх шатны хурлын өмчлөх эрхийн чадавхийг сайжруулж, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хувийн хэвшилд тулгуурласан түншлэлийн бодлогыг эрх зүйд нийцсэн байдлаар удирдах тогтолцоог бүрдүүлэх
2. Төлөөлөгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах менежмент, санхүүгийн нөөцийг бүрдүүлэх
 3. 2013 онд болсон 2014 онд хийхээр төлөвлөгдөж байгаа НӨУБ-ын ажилтай холбоотой улсын чанартай томоохон уулзалт зөвлөлгөөнүүдээс гаргасан зөвлөмж, шийдвэрүүдийг үйл ажиллагаандаа тусган, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд идэвхитэй оролцох
 4. Бүх шатны хурлын төлөөлөгчдийн шийдвэр гаргах түвшний чадавхийг сайжруулах сургалт семинарыг үе шаттай зохион байгуулах
 5. Иргэний танхим, олон нийтийн хэлэлцүүлэг зэрэг оролцооны арга хэлбэрүүдийн ажлын бодит үр дүнг дээшлүүлж, зохион байгуулалт үйл ажиллагааг нь боловсронгуй болгон сайжруулах
 6. Багийн ИНХ-д иргэдийн оролцоог сайжруулах арга зүйг боловсруулж аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч иргэдэд аймгийн бодлого шийдвэрийг танилцуулах, санал хүлээн авах тогтолцоог бүрдүүлэх
 7. Хурлын байгууллагын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх
 8. Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх цогцолборыг байгуулах
 9. Аймгийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх
 10. Хурлын зүгээс хийх хяналт, мониторингийг орон нутгийн татварын баазыг нэмэгдүүлэх, ОНӨ-т үйлдвэрийн газруудын менежментийг сайжруулахад чиглүүлж ажиллах
 11. Аймгийн хурлын төлөөлөгчдийн манлайллыг сайжруулах
 12. Хурлын зүгээс ЗД, түүний тамгын газрын үйл ажиллагааг үнэлэх ажлыг хагас жил тутамд хийж үр дүнг тооцож ажиллах

Тайлан бичсэн : Увс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн

Нарийн бичгийн дарга

/Б.Оюунбат/

Танилцсан : Увс аймгийн ИТХ-ын дарга

/ Ч.Чимэд /